

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг дуустал, анхааралтай уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Энгийн нийгмийн шинж аль нь вэ? \1 оноо\
A. Нийгэмд эд хөрөнгийн ялгаа гараагүй
B. Хүмүүсийн хоорондын олон янзын тогтвортой, өргөн холбоо харилцаа
C. Нийгмийн ялгарал - давхраажил
D. Эрх мэдлийн ялгаа бий болсон
E. Нийгмийг олон түвшинд удирдах төр, засаг бий болсон
2. Аль нь буруу бодомж вэ? \1 оноо\
A. Иргэний нийгмийн улс төрийн үндэс нь эрх мэдлийг төвлөрүүлэх явдал юм
B. Иргэний нийгмийн эдийн засгийн үндэс нь өмчийн олон хэлбэр бүхий зах зээлийн эдийн засгийн харилцаа юм
C. Иргэний нийгэм бол иргэд төртэйгөө хамтарч, харилцан нөлөөлж аж төрөх явдал юм
D. Иргэний нийгмийн оюун санааны үндэс нь ёс суртахууны өндөр хөгжил юм
E. Иргэний нийгмийн төр нь эрх зүйт төр юм.
3. Нийгмийн тухай өргөн ойлголтод аль нь үл хамаарах вэ? \1 оноо\
A. Анхны хүй нэгдлийн нийгэм
B. Монголын нийгэм
C. Феодалын нийгэм
D. Тайж язгууртны нийгэмлэг
E. Боол эзэмшлийн нийгэм
4. Хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
A. Нийгмийн эргэх холбоо
B. Нийгмийн харилцан үйлдэл
C. Нийгмийн үйл ажиллагаа
D. Нийгмийн харилцаа
E. Нийгмийн хууль
5. Үр удмаа нөхөн үйлдвэрлэх, залгамжлах нь нийгмийн институтын чиг үүрэг байдаг. \1 оноо\
A. Боловсролын
B. Шашны
C. Эдийн засгийн
D. Улс төрийн
E. Гэр бүлийн
6. Шинжлэх ухаан, боловсролын үйлчилгээ хөгжиж, техникийн хувьсгал, автоматчлал, компьютер, мэдээллийн технологийг ашигласан өндөр хөгжилтэй зах зээлийн эдийн засагтай зэрэг гол шинжүүдтэй бол энэ нь нийгмийн ямар хэв маяг вэ? \1 оноо\
A. Агнуурын болон түүвэрлэгчдийн нийгэм
B. Газар тариалангийн нийгэм
C. Цэцэрлэгийн аж ахуйн буюу энгийн тариалангийн нийгэм
D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
7. Нийгмийн институтын шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон бол аль нь вэ? \1 оноо\
A. Улс төрийн институт - хууль тогтоомж, эрх зүйн субъект - далбаа, хуулийн эмхэтгэл
B. Эдийн засгийн институт - худалдагч, хүүхэд - харти, загалмай
C. Боловсролын институт - Багш, шавь - үнэмлэх, диплом
D. Шашны институт - хамба, гэсгүй - судар, загалмай
E. Гэр бүлийн институт - эцэг, эх - бөгж, зүүлт
8. Нийгмийн институтуудын цогцыг юу гэж нэрлэдэг вэ? \1 оноо\
A. Нийгмийн систем
B. Нийгмийн институц
C. Нийгмийн үүрэг
D. Нийгмийн практик
E. Нийгэм

9. Газар тариалан (хөдөө аж ахуй)-гийн нийгэмд хамааралгүйг олно уу? \3 оноо\
- A. Хүн ам цөөнтэй хот суурингууд үүссэн
 B. Зээтүү зэргийг ашиглан газар тариалан эрхэлсэн
 C. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг амь зуулгадаа хэрэглэж, газар тариалангийн бүтээгдэхүүнийг худалдаалах болсон
 D. Ураг төрлийн холбоо зонхилсон хэвээр
 E. Энгийн газар тариалан эрхэлж, илүүдэл бүтээгдэхүүн бий болсноор арилжаа үүссэн
10. Нийгмийн амьдралыг дотор нь эдийн засгийн, нийгмийн (социаль), улс төрийн, оюун санааны гэж ангилдаг нь доорх аргуудын алиныг онцлон хэрэглэсний үр дүн бэ? \3 оноо\
- A. Дедукци
 B. Индукци
 C. Синтез
 D. Анализ
 E. Аль нь ч биш
11. Нийгмийн үйл явц дахь зүй тогтолт цогцолбор байдлын илрэлийг юу гэж нэрлэх вэ? \1 оноо\
- A. Нийгмийн үйл явц
 B. Нийгмийн дэвшил
 C. Нийгмийн хөдөлгөөн
 D. Нийгмийн үзэгдэл
 E. Нийгмийн шинэчлэл
12. Хүний статус гэдэг ойлголт аль нь вэ? \3 оноо\
- A. Хүний нийгэмд эзлэх байр суурь болон эрх, үүргийн нэгдлийг илэрхийлсэн ойлголт
 B. Статусаар нөхцөлдсөн бөгөөд хүлээлт бүхий зан үйл, үйлдэл
 C. Дэлхий дахины түүхэн глобаль үйл явц биш
 D. А ба В хариулт зөв
 E. Дээрх бүгд зөв
13. Эцэг, эх тэдний үр хүүхдээс бүрдсэн гэр бүлийг тодорхойлно уу? \3 оноо\
- A. Эгалитар гэр бүл
 B. Өргөжсөн гэр бүл
 C. Нийлмэл гэр бүл
 D. Нуклеар (энгийн буюу хэвийн) гэр бүл
 E. Өрөөсгөл гэр бүл
14. “Улс төр бол хүмүүсийг удирдах урлаг” гэж хэн тодорхойлсон бэ? \1 оноо\
- A. Аристотель
 B. Ф.Бро
 C. Д.Истон
 D. Н.Макиавелли
 E. Х. Лассуэл
15. Аль бодомж нь буруу вэ? \1 оноо\
- A. Засаглалын орон зай гэдэг нь тодорхой хэмжээтэй газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана гэсэн үг
 B. Засаглалын хэмжээ гэдэг нь ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт юм
 C. Засаглалын орон зай бол засаглалын хэмжигдэхүүн биш
 D. Засаглалын эзлэхүүн гэдэг нь хичнээн тооны засаглал хэн нэгний буюу ямар нэгэн байгууллагын гарт төвлөрч байгааг харуулдаг
 E. Засаглалын цаг хугацаа гэдэг нь тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
16. Эрх мэдлийн хэлбэрүүдийг харилцааны төрлөөр нь зөв харгалзааг тогтооно уу \1 оноо\
1. Албадлагын хүч хэрэглэх
 2. Наймаалцах
 3. Үүрэг үүсгэх
- A. Сурагч, сурагчийн дүрмээ заавал биелүүлэх
 B. Сурагч, сурагчийн дүрмээ биелүүлж, боловсролын үйлчилгээ авах
 C. Сурагч, сурагчийн дүрмээ зөрчих
- A. 1A,2C,3B
 B. 1A,2B,3C,
 C. 1B,2C,3A
 D. 1C,2B,3A
 E. 1C,2A,3B
17. Монголчууд “Төрийн минь сүлд өршөө” гэж залбиран төрөө дээдлэх явдал нь аль легитим шинжийг илэрхийлж байна вэ? \1 оноо\
- A. Харизмат легитим шинж
 B. Уламжлалт легитим шинж
 C. Хууль ёсны легитим шинж
 D. А ба В хариулт зөв
 E. Аль ч легитим шинжид хамаарахгүй

18. Улс төрийн тогтолцооны гаралтын илрэл аль нь вэ? \1 оноо\
 А. Шаардлага дэмжлэг В. Оролт С. Шийдвэр үйлдэл
 D. Хувиргалт E. Эргэх холбоо
19. Улс төрийн тогтолцооны Д.Истоны загвар аль нь вэ? \1 оноо\
 А. Орц В. Хувиргалт С. Гарц
 D. Эргэх холбоо E. Дээрх бүгд
20. Сонирхлын бүлгийг илрэх хэлбэрээр ангилсан нь аль вэ? \1 оноо\
 А. Төрийн бус байгууллага В. Лобби бүлэг С. Шахалтын бүлэг
 D. А ба С хариулт зөв E. А ба В, С хариулт зөв
21. Нийгмийн хөдөлмөрийн хуваарь, нэмүү бүтээгдэхүүн, хувийн өмч бий болсноор нийгэм ашиг сонирхлын хувьд эвлэршгүй ангиудад хуваагдсанаар хэсэг бүлэг хүмүүсээс бусдыг албадан ноёрхох болж нэг анги бусад ангийг дарангуйлах замаар төр үүссэн гэж үздэг ангийн онолын төлөөлөгчид аль нь вэ? \1 оноо\
 А. Е. Дюринг, Л.Гумплович, К.Каутский В. С.Августин, Фома Аквинский
 С. К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин D. Цицерон, Г.Гроций, Л.В. Хэллер
 E. Платон, Сен-Симон
22. Төрийн эрх мэдлийг *нийтлэг* гэж тодотгосон бол аль вэ? \2 оноо\
 А. Нийгмийн өмчид тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлдэг
 В. Нийт хүн амаар хүлээн зөвшөөрөгдсөн
 С. Эрх зүйн хэм хэмжээг тогтоон биелүүлдэг
 D. Нийт нутаг дэвсгэр, хүн амыг бүрэн хамардаг
 E. Дээрх бүгд
23. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол аль нь вэ? \1 оноо\
 А. Хуулийг боловсруулах, хууль сахиулах, шүүх
 В. Хууль тогтоох, хуулийг хянах, хууль сахиулах
 С. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
 D. Хууль сахиулах, хууль хэрэгжүүлэх, шүүх
 E. Хууль сахиулах, гүйцэтгэх, хянах
24. Монгол улсын Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхэд хамаарахгүй нь аль вэ? \2 оноо\
 А. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих
 В. Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих...
 С. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх...
 D. Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эргүүлэн татах
 E. Улсын цол, цэргийн цол хүртээх, одон медалиаар шагнах
25. Аль нь социаль төрийн үзэл санаа (шинж) биш вэ? \3 оноо\
 А. Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах
 В. Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах
 С. Төр иргэн хоёр харилцан хариуцлага хүлээх
 D. Шаардлага тулгарсан үед иргэдэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй
 E. Нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн нийгмийн бодлого, халамжийн бодлого явуулах
26. Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох оролцооноос нь хамааруулан улс төрийн намуудыг хэрхэн ангилдаг вэ? \1 оноо\
 А. Ил ба далд В. Олонхи ба нэгдмэл С. Эх баригч ба сөрөг
 D. Бодит ба потенциал E. Хамтарсан ба хамтарсан бус
27. Монгол Улсын Төрийн гүйцэтгэх дээд байгууллага нь: \2 оноо\
 А. Монгол Улсын ерөнхийлөгч В. Монгол Улсын Их Хурал
 С. Монгол Улсын Засгийн Газар D. Улсын дээд шүүх
 E. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц

28. Эдийн засгийн судлах зүйлд хамаарахгүй ойлголт аль нь вэ? \1 оноо\
- A. Үйлдвэрлэлийн үнэ
B. Үйлдвэрлэлийн өсөлтийг хангах
C. Үйлдвэрлэлийн өрсөлдөөн
D. Үйлдвэрлэлийн технологи
E. Үйлдвэрлэлийн осол
29. Аль нэг барааны эрэлт өсөхөд юу нөлөөлөх вэ? \1 оноо\
- A. Хослох барааны үнэ буурах
B. Хослох барааны үнэ өсөх
C. Тухайн барааны үнэ буурах
D. Тухайн барааны үнэ өсөх
E. Бусад барааны үнэ нөлөөлөх
30. Дараах тохиолдлуудын алинд нь зах зээл тогтворжин, эдийн засгийн зохистой байдал бий болох вэ? \1 оноо\
- A. Эрэлт < нийлүүлэлт
B. Эрэлт > нийлүүлэлт
C. Эрэлт = нийлүүлэлт
D. А ба В хариулт зөв
E. Аль нь биш
31. Чөлөөт зах зээлийн үнэ нь \2 оноо\
- A. Хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёуланд нь алдагдалтай
B. Хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёуланд нь ашигтай
C. Хэрэглэгчдэд ашигтай, үйлдвэрлэгчдэд алдагдалтай
D. Хэрэглэгчдэд алдагдалтай, үйлдвэрлэгчдэд ашигтай
E. Бүх хариулт буруу
32. Зөв холбоно уу ? \2 оноо\
- | | | | |
|---|---|----|--|
| 1 | Үндэсний эдийн засгийн нэгдмэл үзүүлэлт | A. | Зөвхөн тухайн орны үйлдвэрлэлийн хүчин зүйлийг ашиглан тэр улсын дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ |
| 2 | Үндэсний нийт бүтээгдэхүүн | B. | Тухайн орны тодорхой нэгж хугацаанд үйлдвэрлэсэн материал баялгийн хэмжээ |
| 3 | Дотоодын нийт бүтээгдэхүүн | C. | Үндэсний нийт бүтээгдэхүүн, дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний цэвэр бүтээгдэхүүн, үндэсний орлого орно |
- A. 1A, 2C, 3B
B. 1A, 2B, 3C
C. 1C, 2A, 3B
D. 1C, 2B, 3A
E. 1B, 2C, 3A
33. Өрсөлдөөн бол зах зээлийн системийг удирдан зохицуулдаг “Үл үзэгдэгч гар” гэж тодорхойлсон эрдэмтэн хэн бэ? \1 оноо\
- A. А.Маршалл
B. Адам Смит
C. М.Кейнс
D. А.М. Фридман
E. К.Маркс
34. Инфляци бол улс орны хэмжээн дэх нийт бараа үйлчилгээний үнийн дүнгээс нийт мөнгөний нь дүнбайдал мөн. \2 оноо\
- A. Их бага нь тодорхойгүй байх
B. Тэнцвэртэй байх
C. Их байх
D. Бага байх
E. Бүгд буруу
35. Өрсөлдөөн шударга явагдаж байгааг аль нь тодорхойлохгүй вэ? \2 оноо\
- A. Ашиг нэмэгдэнэ
B. Зардал буурна
C. Чанар сайн болно
D. Үнэ өснө
E. Сонголт өргөжинө
36. Аль нь ажилгүйдлийг бууруулах гадаад хүчин зүйслийг ашиглах арга замд хамаарах вэ? \2 оноо\
- A. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих
B. Ажиллах хүчийг экспортлох, гадаад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах
C. Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
D. Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх
E. Мэдээллийн сүлжээ бий болгох, мэргэжил олгох, давтан сургах

37. Татвар төлөгч тодорхой хугацаанд олсон орлогоо татварын албанд мэдэгдэх нь татвар ногдуулах ямар арга вэ? \2 оноо\
- A. Декларацийн арга B. Кадастрын арга
C. Бүртгэлийн арга D. Суутгалын арга E. B ба C хариулт
38. Нээлттэй нийгмийн давхраажлын хэв маяг аль нь вэ? \1 оноо\
- A. Каст B. Боолчлол C. Язгуур D. Анги E. Дээрх бүгд
39. Багш Эрдэнэцогт 8 жилийн дотор дадлагажигч багшаас профессор багш болтлоо өсөж хөгжсөн. Энэ жишээ нь нийгмийн шилжих хөдөлгөөний ямар төрлийг илэрхийлэх вэ? \2 оноо\
- A. Үе хоорондын B. Үе доторх C. Бүтцийн
D. Гэр бүлийн E. Нутаг дэвсгэрийн
40. Хүмүүсийг эрх чөлөөгүй болгон үнэ хөлсгүй зарцлах нийгмийн тэгш бус байдлыг илэрхийлсэн давхраажлын хэв маяг аль нь вэ? \1 оноо\
- A. Каст B. Боолчлол C. Язгуур D. Анги E. Аль нь ч биш
41. Хөдөөгийн оршин суугч хотод ирж суурьшин ажил эрхэлж байгаа бол түүний ажил төрөл, мэргэжил, нийгэмд эзлэх байр суурь нь өөрчлөгддөг. Энэ нь дараах өгөгдлүүдээс алинд нь хамаарах вэ? \1 оноо\
- A. Байр суурь үл өөрчлөгдөх шилжилт B. Бүтцийн шилжих хөдөлгөөн
C. Нийгмийн шилжих хөдөлгөөн D. Газар зүйн шилжих хөдөлгөөн
E. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
42. Аль нь нийгмийн даатгалд хамаарахгүй вэ? \1 оноо\
- A. Тэтгэврийн даатгал B. Тэтгэмжийн даатгал
C. Ажилгүйдлийн даатгал D. Арилжааны даатгал
E. Эрүүл мэндийн даатгал
43. 1991 оноос хойш Монгол Улсын Засгийн газар хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоож эхэлсэн бөгөөд тухайлбал, 2013 онд баруун бүсэд 132000 төгрөг, Улаанбаатарт 149900 төгрөг гэх зэргээр бүсчлэн тогтоосон байна. *Хүн амын амьжиргааны доод түвшинг тогтооход* доор дурьдсан үзүүлэлтүүдээс алийг нь ашигласан бэ? \2 оноо\
- A. Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ B. Хүн амын хэрэглээний бүтэц
C. Хүн амын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж D. Хүн амын байршил, газар зүй
E. Дээрх бүгд
44. Амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал аль нь вэ? \1 оноо\
- A. Ядуурлын босго B. Харьцангуй ядуурал C. Ядуурлын хэмжээ
D. Үнэмлэхүй ядуурал E. Аль нь ч биш
45. Орчин үеийн боолчлолын хэлбэр аль нь вэ? \1 оноо\
- A. Хүний наймаа B. Бэлгийн боолчлол C. Хүчинд автан гэрлэх
D. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр E. Дээрх бүгд
46. Буруу бодомж аль нь вэ? \1 оноо\
- A. Соёл хүнд удамшин дамждаг B. Соёлыг өнөө үед сэргээн амьдруулдаг
C. Соёлыг дараагийн үедээ дамжуулдаг D. Зөвхөн А ба С хариулт
E. Буруу утга байхгүй
47. Сөрөг соёлын жишээ аль нь вэ? \1 оноо\
- A. Ардын дуу B. Тоглоомонд донтох C. Харилцааны соёл
D. Ярианы соёл E. Бичгийн соёл

48. Нэр төрийг эрхэмлэх, хөдөлмөрийг дээдлэх нь алинд хамаарах вэ? \1 оноо\
- A. Монгол хэл
C. Монголын бэлгэдэл
B. Монголчуудын шашин шүтлэг
D. Монгол ёс заншил
E. Монгол ухаан
49. Төсөөлөл, үнэт зүйл, үзэл суртал, хэл яриа, мэдлэг, оюуны үйлдвэрлэл ямар соёлд багтах вэ? \1 оноо\
- A. Нийтийн соёл
D. Хэл
B. Материаллаг бус соёл
E. Эдгээрээс өөр
C. Материаллаг соёл
50. Боловсролын түвшингээс хамааралгүйгээр бүх насныхан, бүх давхаргад хүртээмжтэй байдаг соёл аль нь вэ? \1 оноо\
- A. Үндэсний соёл
D. Элит соёл
B. Ардын соёл
E. Дагуул соёл
C. Нийтийн соёл
51. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу? \3 оноо\
- | | |
|------------------|--|
| 1. Үнэлэмж | A. Захирлын тушаал |
| 2. Хэм хэмжээ | B. Нотолгоогүйгээр үнэн гэж зөвшөөрнө гэсэн үг |
| 3. Итгэл үнэмшил | C. Эрхэмлэх болон цээрлэх зүйл |
- A. 1A, 2B, 3C B. 1C, 2A, 3B C. 1C, 2B, 3A D. 1B, 2C, 3A E. 1B, 2A, 3C
52. Аль нь олон улсын соёлын харилцааны хэлбэрийг илэрхийлж байна вэ? \1 оноо\
- A. Бараа үйлчилгээг улс үндэстэн, бүс нутгийн хилээр дамжуулан солилцох
B. Улс орнуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулах, элч төлөөлөгч солилцох
C. Гадаад улс орны эрдэмтэд, судлаачид шинжлэх ухааны тодорхой асуудлаар хамтран судалгаа хийх
D. Олон улсын худалдаа бол хамгийн эртний уламжлалт хэлбэр
E. Төрийн тэргүүний айлчлал
53. НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг гардан хариуцаж ажилладаг байгууллага аль нь вэ? \1 оноо\
- A. Ерөнхий Ассамблей
C. Нарийн бичгийн дарга нарын газар
E. Алинд нь ч хамаарахгүй
B. Аюулгүйн зөвлөл
D. Олон улсын шүүх
54. “Нээлттэй нийгэм Хүрээлэн” олон улсын харилцааны аль субъектэд хамаарах вэ? \2 оноо\
- A. Үндэстэн дамнасан байгууллага
C. Олон улсын байгууллага
E. Алинд нь ч хамаарахгүй
B. Ард түмэн
D. Төр
55. Монгол улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүн хэдэн онд болсон бэ? \1 оноо\
- A. 1946 B. 1960 C. 1961 D. 1962 E. 1990
56. Улс оронд онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хуулиар үл хязгаарлаж болох хүний эрх аль нь вэ? \1 оноо\
- A. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрх, эрх чөлөө
B. Амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөө
C. Гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрх, эрх чөлөө
D. Нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө
E. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ба өв залгамжлуулах

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Гэр бүлийн институт	1	Хоол хүнс, хувцас, хэрэглэл, байр орон сууц олгох
b	Эдийн засгийн институт	2	Хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, халамжлах
c	Улс төрийн институт	3	Сүм хийдийн харилцаа, дэг ёст үйлчлэл, шүтлэг бишрэлийг гүнзгийрүүлэх
d	Шашны институт	4	Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага практикт суралцуулах
e	Боловсролын институт	5	Хууль дүрэм ба хэм хэмжээнүүдийг дэмжих

2.2 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Төрийн албан хаагч	1	Улс төрөөс ангид, мэргэжлийн шалгалтаар томилогдож, тогтвортой ажиллах, төрийн мэргэшсэн албан хаагч
b	Улс төрийн албан хаагч	2	Төрийн байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхэд туслах, хэвийн үйл ажиллагааг хангахад үйлчилдэг. Жишээ нь: багш, эмч гэх мэт
c	Төрийн захиргааны албан хаагч	3	Сонгуулиар сонгодог, зарим тохиолдолд сонгуулийн үр дүнд томилдог. Жишээ нь: Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд, бүх шатны засаг дарга гэх зэрэг
d	Төрийн тусгай албан хаагч	4	Төрөөс цалин хөлс авахаас гадна зарим нэмэлт баталгаагаар хангагдана. Жишээ нь: мэргэшлээ дээшлүүлэх гэх мэт
e	Үйлчилгээний албан хаагч	5	Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал шүүх, цагдаа прокурор гэх мэт албан хаагч

2.3 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Хоршоо (нөхөрлөл)	1	Нэг бүрийн нэрлэсэн үнэ бүхий тодорхой тоо хэмжээний хувьцаанаас бүрдсэн дүрмийн сантай, эзэмшигч нь захиалсан хувьцааныхаа нийт үнийн хэмжээгээр хариуцлага хүлээдэг
b	Компани (бүрэн бус хариуцлагатай)	2	Үйл ажиллагааны тодорхой төрлүүдийг хууль зүйн үндсэн дээр нэгтгэн бизнес явуулдаг, эзэмшигч нь оруулсан хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг
c	Хувьцаат компани	3	Хоёр ба түүнээс дээш хүмүүс тодорхой хэмжээний хөрөнгө хүчээ нэгтгэж, ямар нэгэн ажил хариуцан, ашиг алдагдлаа хуваахаар тохиролцон үүсгэсэн, арилжааны шинжтэй
d	Улсын үйлдвэрийн газар	4	Тодорхой тоо хэмжээ нэг бүрийн тэнцүү үнэлгээ бүхий ногдол хувьд хуваагдах дүрмийн сантай, гишүүд нь оруулсан хувь хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг
e	Корпораци	5	Улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан, өмчлөгч нь төр дангаараа байдаг

2.4 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

a	Дээд ангийн дээд давхраа	1	Хүн амын гуравны нэг хувийг эзэлдэг, шийдвэр гаргах эрх мэдэл, нөлөөгүй
b	Дээд ангийн доод давхраа	2	Хүн амын өчүүхэн хувийг эзлэх боловч, асар их хэмжээний баялаг эзэмшдэг, залгамжилсан угсаа гарвал өмч хөрөнгөтэй, эдийн засаг, улс төрийн их нөлөө, нэр хүндтэй
c	Дунд ангийн дээд давхраа	3	Хүн амын мөн гуравны нэг хувийг эзэлдэг, Мэргэжилтэй, мэргэжилгүйгээс хамаарч хөдөлмөр нь өөр өөр үнэлэгддэг
d	Дунд ангийн доод давхраа	4	Гол төлөв шинээр төрсөн баячууд бөгөөд тэд асар их баялагтай ч дээд давхраа шигээ удам угсаа, нэр хүндийг олоогүй байдаг
e	Ажилчин анги	5	Хүн амын 15 орчим хувийг эзэлдэг, өндөр нэр хүндтэй, шийдвэр гаргахад оролцдог

